

УБ хотын ХЭХТөвийн харъяа “ИВЭЭЛ” МХБүлгийн 2020 оны үйл ажиллагааны тайлан

ЗОРИЛГО:

Гишүүд сайн дурын үндсэн дээр эвлэлдэн нэгдэж бие биенээ итгэж , хүндэлж идэвхи санаачлагатайгаар хамтран ажиллахад оршино.

Бидний уриа:

Бүтээнэ гэсэн нэгхэн хүслээрээ
Бүхий л амьдралаа гэрэлтүүлж
Болгоно гэсэн гэгээн сэтгэлээрээ
Босго нь өндөр амжилт руу тэмүүлж явцгаая

“ИВЭЭЛ” МХБүлэг

- “ИВЭЭЛ” бүлэг нь 2005 оны 09 сарын 10 нд байгуулагдсан.
- 8-н гишүүнтэй
- Сарын хуримтлал 10,000 төг
- Сар бүрийн 5-25-ны дотор бүлгийн хурлаа **тогтмол** хийдэг.
- Үндсэн хуримтлал болон Эрсдлийн сантай
- ХЭХТөвөөс хөнгөлөлттэй зээл болон төрөл бүрийн төсөл хөтөлбөрт хамрагдсанаар тус бүлгийн 8-н гишүүний ар гэрийн 60 гаруй иргэдийн аж амьдрал, амьжиргаа орчин нөхцөл сайжирч төрөл бүрийн хурал цуглаан, чуулга уулзалт, хэлэлцүүлэгт гишүүд хамрагдаж мэдээ мэдээллээр хангагдаж чадавхижсан.

“ИВЭЭЛ” МХБүлгийн 15-н жилийн ой 2020.09.12

2020.09.12 нд Туул тосгонд гишүүн Д.Лхагваагын 15 жилийн ойгоо тэмдэглэсэн. Ойнбаярт ХЭХТөвийн тэргүүн Г.Уранцоож, ХОСХХөтөлбөрийн зохицуулагч, дэд захирал У.Мандхайцэцэн МХБХолбооны дарга Ц.Оюунчимэг, “Сор” МХБүлгийн гишүүн Б.Оюунбилэг, Бурмаа нар уригдан ирсэн. “ИВЭЭЛ” бүлгийн гишүүд тэдгээрийн ар гэрийн 20 гаруй хүмүүс оролцон баяраа тэмдэглэсэн.





2020 оны 09 сарын 19-21 ныг хүртэл Дорнод аймгийн Баян-дун сумын МХБХолбооны Хамт олныг хөгжүүлэх төвөө шинээр барьж ашиглалтанд оруулсны нээлтийн үйл ажиллагаанд ХЭХТөв, Улаанбаатар, Дархан, Өвөрхангай, Дорнод, Хэнтий зэрэг аймаг, хотуудын МХБХолбооны гишүүдийн төлөөлөл оролцсон.



2020 оны 09 сарын 21-23 ны өдрүүдэд Дорнод, Хэнтий аймгийн МХБХолбоодын гишүүдтэй уулзалт хийж санал бодлоо солилцов

